

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн тусгай хамгаалалтын зорилго, хамрах хүрээ, зохион байгуулалт болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн баталгааг тогтоож, хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомж

2.1.Төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“биеийн хүч хэрэглэх” гэж төрийн тусгай хамгаалалтын алба хаагч өөрийн бие махбод, мэргэжлийн тусгай бэлтгэлийг ашиглан бусдын хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор биеэр хийх үйлдлийг;

3.1.2.“объектын аюулгүй байдал” гэж энэ хуульд заасны дагуу төрийн тусгай хамгаалалтад байгаа объект аливаа аюул, халдлагаас хамгаалагдсан байдлыг;

3.1.3.“төрийн тусгай хамгаалалтын бүс” гэж төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуульд заасны дагуу тогтоосон тодорхой орчин, нутаг дэвсгэрийг;

3.1.4.“хамгаалалтын техникийн үзлэг” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авахад зориулсан техник, тоног төхөөрөмжийг илрүүлэхэд чиглэсэн төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас энэ

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

хуульд заасны дагуу тусгай техник хэрэгсэл ашиглан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг;

3.1.5.“хамгаалуулагч” гэж төрийн тусгай хамгаалалтад авахаар энэ хуульд заасан албан тушаалтан, хүнийг;

3.1.6.“хамгаалуулагчийн аюулгүй байдал” гэж төрийн тусгай хамгаалалтад байгаа албан тушаалтан, хүний амь бие аливаа аюул, халдлагаас хамгаалагдсан байдлыг;

3.1.7.“шадар хамгаалалт” гэж хамгаалуулагчийг биечлэн хамгаалахыг.

4 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын зарчим

4.1.Төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана:

4.1.1.хууль дээдлэх;

4.1.2.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

4.1.3.улс төрөөс ангид байх;

4.1.4.нууцыг чанд хадгалах;

4.1.5.иж бүрэн байх;

4.1.6.тасралтгүй байх;

4.1.7.шинжлэх ухааны болон орчин үеийн техник, технологийн ололтыг

ашиглах;

4.1.8.хамтран ажиллах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТ

5 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалт

5.1.Төрийн тусгай хамгаалалт нь хамгаалуулагч болон хамгаалалтад байгаа объектын аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлж байгаа эрх зүй, удирдлага, зохион байгуулалт, хамгаалалт, үйлчилгээ, техник, технологийн болон бусад арга хэмжээний цогц байна.

5.2.Төрийн тусгай хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны салшгүй хэсэг бөгөөд төрийн хууль тогтоох, гүйцэтгэх дээд байгууллагын хэвийн, найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааг хангахад чиглэсэн тусгай албаны үйл ажиллагаа мөн.

5.3.Төрийн тусгай хамгаалалтыг ил болон далд хэлбэр, тусгай арга, хэрэгслээр зохион байгуулна.

6 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, хүн, хамгаалалтад байх хугацаа

6.1. Дараах албан тушаалтан, хүн төрийн тусгай хамгаалалтад байна:

6.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд;

6.1.2. Монгол Улсын Их Хурлын даргын болон Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч;

6.1.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч;

6.1.4. Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигч;

6.1.5. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд асан хүн;

6.1.6. Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, парламентын дарга, тэдгээрийг дагалдан яваа эхнэр /нөхөр/;

6.1.7. Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад орны дэд ерөнхийлөгч, гадаад хэргийн сайд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, гадаад улсын төр, засгийн газрын тэргүүний бие төлөөлөгч, гадаад улсын төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнж.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан хамгаалуулагч дор дурдсан хугацаанд төрийн тусгай хамгаалалтад байна:

6.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хугацаанд;

6.2.2. энэ хуулийн 6.1.2-т заасан хүн Монгол Улсын Их Хурлын даргын болон Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэх хугацаанд;

6.2.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч хуульд заасны дагуу түүнийг нэр дэвшсэн талаар нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн сонгуулийн албан ёсны дүн гарах хүртэлх хугацаанд;

6.2.4. Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигч нэр дэвшсэн өдрөөс албан ёсны шийдвэр гарах хүртэлх хугацаанд;

6.2.5. Монгол Улсын Ерөнхийлөгч асан хүн бүрэн эрхийнх нь хугацаа дууссанаас эхлэн 3 жил, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд асан хүн бүрэн эрхийнх хугацаа дууссанаас эхлэн 2 жилийн хугацаанд;

6.2.6. энэ хуулийн 6.1.6, 6.1.7-д заасан зочин Монгол Улсад айлчлах хугацаанд.

6.3. Энэ хуулийн 6.1.1-д заасан хамгаалуулагчийн албан үүрэгтэй нь холбогдуулан түүний эхнэр /нөхөр/, 18 насанд хүрээгүй хүүхдийн амь биед гадны аюул учирч болзошгүй тохиолдолд тухайн нөхцөл байдал арилах хүртэл тэднийг Төрийн

тусгай хамгаалалтын байгууллага төрийн тусгай хамгаалалтад түр хугацаагаар авч болно.

6.4.Энэ хуулийн 6.1.3-т заасан нэр дэвшигчийн мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороо, 6.1.4-т заасан нэр дэвшигчийн мэдээллийг Улсын Их Хурлын Тамгын газар, 6.1.6, 6.1.7-д заасан хамгаалуулагчийн мэдээллийг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тус тус Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад хүргүүлнэ.

7 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын зэрэглэл, хамрах хүрээ

7.1.Төрийн тусгай хамгаалалт дараах зэрэглэлтэй байна:

7.1.1.нэгдүгээр зэрэглэл;

7.1.2.хоёрдугаар зэрэглэл;

7.1.3.гуравдугаар зэрэглэл.

7.2.Энэ хуулийн 6.1-д заасан хамгаалуулагч дараах зэрэглэлээр төрийн тусгай хамгаалалтад байна:

7.2.1.нэгдүгээр зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад энэ хуулийн 6.1.1, 6.1.6-д заасан хамгаалуулагч;

7.2.2.хоёрдугаар зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад энэ хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан болон Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа энэ хуулийн 6.1.7-д заасан хамгаалуулагч;

7.2.3.гуравдугаар зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад энэ хуулийн 6.1.4, 6.1.5, 6.3-т заасан болон Монгол Улсад ажлын айлчлал хийж байгаа энэ хуулийн 6.1.7-д заасан хамгаалуулагч.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан төрийн тусгай хамгаалалтын зэрэглэл тус бүрийн онцлогт тохирсон хүч хэрэгслийн хэмжээ, тэдгээрийг хамгаалалтын тухайн нөхцөл байдалд нийцүүлэн зохицуулах журмыг Засгийн газар батална.

7.4.Энэ хуулийн 7.2.1, 7.2.2-т заасан хамгаалуулагч, шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийн зочлох барилга байгууламж, түр байрлах орон байр, нутаг дэвсгэрт болон зорчих зам маршрутын дагуу төрийн тусгай хамгаалалтыг зохион байгуулна.

8 дугаар зүйл.Хамгаалуулагчийн хүлээх үүрэг

8.1.Хамгаалуулагч аюулгүй байдлыг нь хангахтай холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын байгууллага, алба хаагчаас тавьсан хууль ёсны хүсэлт, шаардлагыг хүндэтгэн биелүүлнэ.

8.2.Энэ хуулийн 6.1.6, 6.1.7-д зааснаас бусад төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, хүн төрийн тусгай хамгаалалтаас татгалзахыг хориглоно.

9 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалт түр зогсох

9.1.Хамгаалуулагч гэмт хэрэгт холбогдон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацаанд түүний төрийн тусгай хамгаалалт түр зогсоно.

9.2.Хамгаалуулагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол хорих болон баривчлах ял эдлэх хугацаанд, зөрчил үйлдсэн нь тогтоогдож шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол баривчлах шийтгэл эдлэх хугацаанд түүний төрийн тусгай хамгаалалт түр зогсоно.

9.3.Энэ хуулийн 9.1, 9.2-т заасан тохиолдолд шүүхийн холбогдох шийдвэрийн хувийг тухайн шүүх Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

9.4.Төрийн тусгай хамгаалалт түр зогсох нь хуульд заасан хамгаалалтын хугацааг нөхөх үндэслэл болохгүй.

10 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтад байх объект

10.1.Дараах хуралдаан төрийн тусгай хамгаалалтад байна:

10.1.1.Улсын Их Хурлын чуулганы хуралдаан;

10.1.2.Засгийн газрын хуралдаан;

10.1.3.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан.

10.2.Доор дурдсан барилга байгууламж, нутаг дэвсгэр төрийн тусгай хамгаалалтад байна:

10.2.1.Монгол Улсын Төрийн ордон;

10.2.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын ажлын байр, зориулалтын орон сууц, тэдгээрт хамаарах нутаг дэвсгэр;

10.2.3.төрийн тусгай хамгаалалтын зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа барилга байгууламж, тэдгээрт хамаарах нутаг дэвсгэр.

10.3.Хамгаалуулагчийн хөлөглөн яваа болон зориулалтын тээврийн хэрэгсэл төрийн тусгай хамгаалалтад байна.

10.4.Олон улсын дээд хэмжээний хурал, уулзалт, хэлэлцээг төрийн тусгай хамгаалалтад авах асуудлыг Засгийн газар тухай бүр шийдвэрлэнэ.

10.5.Энэ хуульд зааснаас бусад объектыг төрийн тусгай хамгаалалтад авах, хамгаалалтаас гаргах асуудлыг энэ хуулийн 5.2-т заасныг болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын бүс

11.1.Хамгаалуулагчийн болон төрийн тусгай хамгаалалтад байгаа объектын аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн тусгай хамгаалалтын бүс тогтооно.

11.2.Төрийн тусгай хамгаалалтын бүс байнгын болон түр байна.

11.3.Төрийн тусгай хамгаалалтын байнгын бүсийг дараах байдлаар тогтооно:

11.3.1.энэ хуулийн 10.1, 10.5-д заасан объектын төрийн тусгай хамгаалалтын бүсийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага;

11.3.2.энэ хуулийн 10.2-т заасан объектын төрийн тусгай хамгаалалтын бүсийг тухайн объектод хамаарах нутаг дэвсгэрийн хязгаараар;

11.4.Төрийн тусгай хамгаалалтын түр бүсийг дараах байдлаар тогтооно:

11.4.1.энэ хуулийн 7.4-т заасан барилга байгууламж, орон байр, нутаг дэвсгэрийн төрийн тусгай хамгаалалтын бүсийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч;

11.4.2.энэ хуулийн 10.4-т заасан объектын төрийн тусгай хамгаалалтын бүсийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага.

12 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын бүсэд хориглох зүйл

12.1.Төрийн тусгай хамгаалалтын бүсэд дараах зүйлийг хориглоно:

12.1.1.зөвшөөрөлгүй болон шалган нэвтрүүлэх ажиллагаанд хамрагдахгүйгээр нэвтрэх;

12.1.2.төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий албан хаагчаас бусад хүн зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгсэлтэй нэвтрэх;

12.1.3.дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг зөвшөөрөлгүй хийх, дамжуулах;

12.1.4.хамгаалалтын дэглэм зөрчих;

12.1.5.хуулиар хориглосон, хязгаарласан эд зүйл авч орох;

12.1.6.төрийн тусгай хамгаалалтын бүсийн агаарын зайд нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлөг зөвшөөрөлгүй нисгэх;

12.1.7.жагсаал, цуглаан хийх, өлсгөлөн, суулт зарлах.

12.2.Төрийн тусгай хамгаалалтын бүс, түүний орчинд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд цэрэг, зэвсэг, техникийн хүч хуралдуулахыг хориглоно.

13 дугаар зүйл.Хамгаалалтын дэглэм

13.1.Төрийн тусгай хамгаалалтын бүсэд гарч болзошгүй халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг илрүүлэх, таслан зогсоох, зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгсэл, бусад зүйл, хуулиар хориглосон, хязгаарласан эд зүйл

нэвтрүүлэхгүй байх болон хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хамгаалалтын дэглэм тогтооно.

13.2.Хамгаалалтын дэглэмээр тодорхой эд зүйл нэвтрүүлэхийг хориглох, зорчих хөдөлгөөн хязгаарлах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг түр зогсоох болон хяналтын дэг журам тогтоож болно.

13.3.Хамгаалалтын дэглэм сахиулах зорилгоор бичиг баримт шалгах, бүртгэх, хүний бие, эд зүйл болон тээврийн хэрэгсэлд үзлэг хийж шалган нэвтрүүлэх ажиллагаа явуулна.

13.4.Шалган нэвтрүүлэх ажиллагааг техник хэрэгсэл ашиглан явуулж болно.

13.5.Хамгаалалтын дэглэмийг сахиулах зорилгоор энэ хуульд заасан бусад үйл ажиллагааг явуулж болно.

14 дүгээр зүйл.Аюулгүй байдлын үзлэг

14.1.Хамгаалуулагч болон хамгаалалтад байгаа объектын аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор аюулгүй байдлын үзлэг хийнэ.

14.2.Аюулгүй байдлын үзлэг нь урьдчилан сэргийлэх, хамгаалалтын техникийн, орчны болон эрүүл ахуйн үзлэг гэсэн төрлүүдтэй байна.

14.3.Урьдчилан сэргийлэх, орчны болон эрүүл ахуйн үзлэг хийх журам, зааврыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

14.4.Хамгаалалтын техникийн үзлэгийг энэ хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

15 дугаар зүйл.Хамгаалалтын техникийн үзлэг

15.1.Хамгаалалтын техникийн үзлэгийг Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний хурал явагдах танхим, хамгаалуулагчийн ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл болон түр байрлах орон байр, албан тасалгаанд хийнэ.

15.2.Хамгаалалтын техникийн үзлэгийг энэ хуулийн 15.1-д зааснаас бусад газарт хийхийг хориглоно.

15.3.Хамгаалалтын техникийн үзлэг хийх зааврыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

16 дугаар зүйл.Урьдчилсан хамгаалалт

16.1.Хамгаалалтыг төлөвлөх, бэлтгэл ажлыг хангах зорилгоор хамгаалуулагчийн очих барилга байгууламж, нутаг дэвсгэрт болон зорчих зам маршрутын дагуу урьдчилсан хамгаалалт зохион байгуулна.

16.2.Урьдчилсан хамгаалалтын үед төрийн тусгай хамгаалалт найдвартай байхад чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авна.

16.3.Урьдчилсан хамгаалалтыг гадаад улсад зохион байгуулж болно.

17 дугаар зүйл.Объектын аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага

17.1.Төрийн тусгай хамгаалалтад байх барилга байгууламжийг камерын хяналтын систем, шалган нэвтрүүлэх тоног төхөөрөмж болон аюулгүй байдлыг нь хангахад шаардлагатай бусад техник хэрэгслээр бүрэн тоноглоно.

17.2.Төрийн тусгай хамгаалалтад авсан барилга байгууламж, тэдгээрийн инженерийн байгууламж нь гамшгийн аюулаас найдвартай хамгаалагдсан байх бөгөөд холбогдох мэргэжлийн байгууллагын байнгын хяналтад байна.

17.3.Төрийн тусгай хамгаалалтад авсан барилга байгууламжийн цахилгаан, дулааны эрчим хүч, холбоо, усан хангамжийг зогсоож үл болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ИРГЭНИЙ ОРОЛЦОО, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

18 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллага

18.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлнэ.

18.2.Төрийн бусад байгууллагууд чиг үүрэг, энэ хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлж оролцоно.

19 дүгээр зүйл.Тагнуулын байгууллагын үүрэг

19.1.Хамгаалуулагчийн аюулгүй байдал болон хамгаалалтад сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээ, мэдээллээр Төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг тогтмол, шуурхай хангаж, шаардлагатай бусад дэмжлэг, туслалцааг үзүүлэх үүрэгтэй.

19.2.Тагнуулын байгууллагын орон нутаг дахь салбар, нэгж тухайн орон нутагт хэрэгжүүлэх төрийн тусгай хамгаалалтад хамтран оролцох цагдаагийн болон бусад байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

19.3.Тагнуулын байгууллага нь Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай харилцан ажиллах, мэдээлэл солилцох журмыг хамтран баталж хэрэгжүүлнэ.

20 дугаар зүйл.Цагдаагийн байгууллагын үүрэг

20.1.Төрийн тусгай хамгаалалтад шаардагдах эрүүгийн нөхцөл байдлын мэдээг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад цаг тухайд нь өгч, шаардлагатай бусад дэмжлэг, туслалцааг үзүүлэх үүрэгтэй.

20.2.Нэг, хоёрдугаар зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад байгаа хамгаалуулагч, шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг баяр ёслол, олон нийтийн болон бусад арга хэмжээнд оролцох, автотээврийн хэрэгслээр зорчих, орон нутагт байх үед хөтөч машин ажиллуулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, хэв журмын хамгаалалт зохион байгуулна.

20.3.Төрийн тусгай хамгаалалтад авсан барилга байгууламж, бусад зүйлийн орчинд гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл ажиллуулна.

20.4.Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн буюу үүсэж болзошгүй бодитой нөхцөлд төрийн тусгай хамгаалалтад хүч нэмэгдүүлж хамтран ажиллана.

20.5.Цагдаагийн байгууллага нь Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай харилцан ажиллах журмыг хамтран баталж хэрэгжүүлнэ.

21 дүгээр зүйл.Онцгой байдлын байгууллагын үүрэг

21.1.Төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга байгууламж, бусад зүйлийг галын аюулаас хамгаалж, гамшиг, онцгой байдлын үед Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах үүрэгтэй.

21.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлнэ.

21.3.Онцгой байдлын асуудлын эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.

22 дугаар зүйл.Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

22.1.Хамгаалуулагчийн эрүүл мэндийг онцлон хамгаалах үүрэгтэй.

22.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

22.3.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.

23 дугаар зүйл.Мэргэжлийн хяналтын байгууллагын үүрэг

23.1.Хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа орчинд болон хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хөндлөнгийн хяналтыг тогтмол тавьж, Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр лабораторийн шинжилгээ хийх бөгөөд

холбогдох мэдээ, мэдээллээр Төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг шуурхай хангах үүрэгтэй.

23.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллана.

23.3.Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран ажиллах журам баталж хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл.Бусад байгууллага, албан тушаалтны үүрэг

24.1.Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан, ашгийн төлөө бус байгууллага Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр холбогдох мэдээ, судалгаа гарган өгч, шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

24.2.Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, ашгийн төлөө бус байгууллага төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

24.3.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн ёслолын асуудал хариуцсан байгууллага нь хамгаалуулагчийн оролцох төрийн ёслол, хүндэтгэлийн болон бусад арга хэмжээний талаар Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад мэдээлэл өгч, хамгаалалтын талаархи санал зөвлөгөөг тусгаж ажиллах үүрэгтэй.

24.4.Хамгаалуулагчийг гадаад оронд айлчлах, дамжин өнгөрөх үед тухайн оронд байгаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар хамгаалалтын ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

24.5.Иргэний болон улсын нисэхийн байгууллага нь хамгаалуулагчийн хөлөглөн явах агаарын хөлгийн техникийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

24.6.Төмөр замын байгууллага нь хамгаалуулагчийн хөлөглөн явах галт тэрэгний зам, техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

24.7.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр үйлчилгээний байгууллага шаардлагатай үед хамгаалуулагчийг найдвартай, шуурхай харилцаа холбоогоор хангаж, түүний нууцлалыг хамгаалах ба төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

24.8.Шаардлагатай тохиолдолд зэвсэгт хүчин, хилийн цэрэг төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах үүрэгтэй.

25 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд хүний хүлээх үүрэг

25.1.Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хуульд нийцүүлэн тавьсан хүсэлт, шаардлагыг биелүүлж, бүхий л бололцоотой дэмжлэг тусалцаа үзүүлэх үүрэгтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

26 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага

26.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь төрийн тусгай хамгаалалтын чиг үүргийг хуульд заасан хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлэх Засгийн газрын тохируулагч агентлаг байна.

26.2.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь төрийн тусгай хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцсэн хамгаалалт, дүн шинжилгээ, хангалт, үйлчилгээ, захиргаа болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх үүргийг хэрэгжүүлэх нэгжүүд бүхий үндсэн бүтэцтэй байна.

26.3.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь харьяандаа дээд боловсролын байгууллага, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, эмнэлэг, нөхөн сэргээх төв, туслах аж ахуйтай байж болно.

26.4.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын төрийн тусгай хамгаалалтын зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, газрын төлбөрөөс чөлөөлнө.

26.5.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, сүлжээг Засгийн газар тогтооно.

27 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын бүрэн эрх

27.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1.төрийн тусгай хамгаалалтыг зохион байгуулах;

27.1.2.хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн төрийн тусгай үйлчилгээг үзүүлэх;

27.1.3.төрийн тусгай хамгаалалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

27.1.4.төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагуудыг төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр арга зүйгээр хангах, чиглүүлэх, төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;

27.1.5.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

27.1.6.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, холбогдох мэдээ, мэдээллээр шуурхай хангагдах, дүн шинжилгээ хийх;

27.1.7.төр, орон нутгийн болон олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулж авах;

27.1.8.чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан тусгай зориулалтын техник хэрэгсэл, мэдээллийн сантай байх, тэдгээртэй холбоотой засвар, үйлчилгээ, инженерийн дэд бүтцээр хангагдах;

27.1.9.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхдээ тухайн аюулгүй байдлыг хангах нөхцөл, хэрэгцээ, шаардлагыг харгалзан энэ хуульд заасны дагуу төрийн тусгай хамгаалалтын бүс, хамгаалалтын дэглэм тогтоох, хяналт тавих;

27.1.10.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд явган зорчигч, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд түр зогсоох, чиглэлийг өөрчлүүлэх;

27.1.11.энэ хуулийн 6.1.1-д заасан болон шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг орон нутагт агаарын хөлөг, усан онгоц, галт тэргээр зорчин явах үед аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор уг тээврийн хэрэгслээр тухайн үед зорчих хүмүүс, тэдний ачаа тээшийг шалгахад, түүнчлэн хамгаалуулагчийг гадаадад явах үед хамт явах зорчигчдод Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хяналт шалгалт хийхэд алба хаагчаа байлцуулах;

27.1.12.урьдчилсан хамгаалалт хэрэгжүүлэх, аюулгүй байдлын үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах;

27.1.13.аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын бүсэд радио холбооны сүлжээ сарниулах, радио төхөөрөмжийн үйл ажиллагааг түр зогсоох;

27.1.14.хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга байгууламж, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед болон шаардлагатай бусад тохиолдолд тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага болон зэвсэгт хүчин, хилийн цэргээс дэмжлэг авах, хамтран ажиллах;

27.1.15.төрийн байгууллагын төвлөрсөн болон бусад мэдээллийн санд шуурхай нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах;

27.1.16.төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг далдлахын тулд өөр байгууллагын баримт бичиг, албаны дүрэмт хувцас болон бусад зүйлийг ашиглах;

27.1.17.тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх;

27.1.18.гадаад орны төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

27.1.19.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд хүсэлт, шаардлага тавих;

27.1.20.хуульд заасан бусад.

28 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын үүрэг

28.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага дараахь үүрэгтэй байна:

28.1.1.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах;

28.1.2.төрийн тусгай хамгаалалтад авсан объектыг хамгаалах;

28.1.3.энэ хуулийн 6.1.1-д заасан хамгаалуулагчийг өргөө, зориулалтын орон сууц, үйлчлэх бүрэлдэхүүн, эдийн болон хүнсний бүтээгдэхүүнээр хангах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;

28.1.4.хамгаалуулагчийн өргөө, зориулалтын орон сууцны ашиглалтын техникийн бэлэн байдлыг хангах, засвар үйлчилгээг хариуцах;

28.1.5.хамгаалуулагчид зориулалтын тээврийн хэрэгсэл, тусгай холбоогоор үйлчлэх;

28.1.6.төрийн тусгай хамгаалалтын бүс, тэдгээрийн орчинд холбогдох байгууллагуудтай хамтран инженер-техникийн үзлэг, шалгалт хийж аюулгүй байдлыг хангах;

28.1.7.төрийн тусгай хамгаалалтын бүсэд хамгаалалтын дэглэм сахиулах, халдлага, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах;

28.1.8.бүрэн эрхийнхээ хүрээнд террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох;

28.1.9.үйл ажиллагаандаа шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад хяналтын систем нэвтрүүлэх;

28.1.10.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай өөрт нь мэдээлж, танилцуулах;

28.1.11.байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

29 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын туг, бэлгэ тэмдэг

29.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага туг, бэлгэ тэмдэгтэй байна.

29.2.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Засгийн газар батална.

29.3.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын туг, бэлгэ тэмдэгтэй ижил загварын туг, бэлгэ тэмдэгийг хүн, хуулийн этгээд хэрэглэхийг хориглоно.

30 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын төсөв

30.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь чиг үүргээ иж бүрэн, тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

30.2.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг ажлын байр, шаардлагатай зэвсэг, тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж, тээврийн болон бусад техник хэрэгсэл, албан хаагчийг орон сууцаар хангахтай холбогдсон зардал болон хамгаалалтад байгаа объектын аюулгүй байдлыг хамгаалахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

30.3.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж, санал болгосноор Улсын Их Хурал батална.

31 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын удирдлага

31.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргаар Төрийн албаны тухай хууль²д заасан нийтлэг шаардлагаас гадна төрийн тусгай албанд 16-аас доошгүй жил, үүнээс төрийн тусгай хамгаалалтын албанд 5-аас доошгүй жил ажилласан, удирдах болон хамгаалалтын ажлын дадлага туршлагатай Монгол Улсын иргэнийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдтэй зөвшилцөн Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

31.2.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь хамгаалалтын үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд, захиргааны удирдлагын үйл ажиллагаа хариуцсан болон төрийн тусгай үйлчилгээ, хангалт хариуцсан 2 дэд даргатай байна.

31.3.Энэ зүйлийн 31.2-т заасан тэргүүн дэд, дэд даргаар Төрийн албаны тухай³ хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна төрийн тусгай албанд 16-аас доошгүй жил, үүнээс төрийн тусгай хамгаалалтын албанд сүүлийн 5-аас доошгүй жил тасралтгүй ажилласан, удирдах болон хамгаалалтын ажлын дадлага туршлагатай, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй Монгол Улсын иргэнийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргын саналыг үндэслэн Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.

² Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

³ Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

31.4.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, тэргүүн дэд, дэд даргыг дараах тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

31.4.1.өөрөө хүсэлт гаргасан;

31.4.2.биеийн эрүүл мэндийн байдлын улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

31.4.3.хуульд заасан бусад.

31.5.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, тэргүүн дэд, дэд дарга гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол энэ өдрөөс эхлэн түүнийг албан тушаалаас нь чөлөөлсөнд тооцно.

31.6.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга гэмт хэрэгт холбогдсон, баривчлагдсан бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулсан бол уг саналыг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

31.7.Хуульд зааснаас бусад үндэслэлээр Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, тэргүүн дэд, дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх буюу халах, чөлөөлөхийг хориглоно.

32 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргын бүрэн эрх

32.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн⁴ 8.3-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.төрийн тусгай хамгаалалтын байгууллагын үйл ажиллагааг удирдах, бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал, шийдвэр гаргах;

32.1.2.төрийн тусгай хамгаалалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

32.1.3.төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;

32.1.4.энэ хуульд заасны дагуу төрийн тусгай хамгаалалтын бүс, хамгаалалтын дэглэм тогтоох;

32.1.5.энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан хамгаалалтын техникийн үзлэг хийх зөвшөөрөл олгох;

32.1.6.төрийн тусгай хамгаалалтын бүсийн агаарын зайд нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлөг нисгэх зөвшөөрөл олгох;

⁴ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.

32.1.7.төрийн тусгай хамгаалалтын бүсэд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, дамжуулах зөвшөөрөл өгөх;

32.1.8.төрийн тусгай хамгаалалтад оролцож байгаа бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж удирдан зохион байгуулах;

32.1.9.төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах;

32.1.10.төрийн тусгай хамгаалалтын байгууллагын барилга байгууламж, автомашин, зэвсэг, техник, тусгай хэрэгсэл, хувцас, бусад хангамжийн талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

32.1.11.төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

32.1.12.хүний нөөцийн бодлого боловсруулж, алба хаагч, ажилтныг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, мэргэшлийн зэрэг олгох;

32.1.13.цэргийн цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх.

32.1.14.байгууллага, албан хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

32.1.15.хуульд заасан бусад.

32.2.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргын түр эзгүйд түүний бүрэн эрхийг тэргүүн дэд дарга хэрэгжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

33 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч

33.1.Энэ хуульд заасан тангараг өргөж, төрийн тусгай хамгаалалтын албанд томилогдон ажиллаж байгаа төрийн тусгай албан хаагчийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч гэнэ.

33.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд тавигдах тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлт нь албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлага, төрийн тусгай хамгаалалтын албанд болон мэргэжлийн чиглэлээр ажилласан жил зэргээс бүрдэнэ.

33.3.Төрийн тусгай хамгаалалтын албанд ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлтийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тогтооно.

33.4.Энэ хуулийн 6.1.1-д заасан хамгаалуулагчийн шадар хамгаалалтад хамгаалалтын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, мэргэшүүлэх сургалтад хамрагдаж шадар хамгаалалтын ажилтны нөөцөд бүртгэлтэй төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг томилно.

33.5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд анх орох иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

33.6.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад шаардлагатай мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор иргэнтэй гэрээ байгуулан дотоод, гадаадын боловсролын байгууллагад сурган, томилж болно.

33.7.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын үйлчилгээний албан хаагчдын эрх зүйн байдалтай холбоотой харилцааг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Төрийн албаны тухай хууль⁵, Хөдөлмөрийн тухай хуулиар⁶ зохицуулна.

33.8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Хөдөлмөрийн тухай хуулиар⁷ тогтоосон ээлжийн амралт эдэлнэ.

34 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг

34.1.Монгол Улсын иргэн төрийн тусгай хамгаалалтын албанд анх орохдоо Төрийн сүлдэнд: "Монгол Улсын иргэн Би, төрийн тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ төрөө хүндэтгэн, хууль ёсыг дээдэлж, төрийн нууцыг чанд хадгалан, хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, амь биеэ үл хайрлан ажиллахаа батлан тангараглая. Би энэ тангаргаасаа няцваас төрийн хуулийн цээрлэл хүлээнэ." хэмээн Тангараг өргөнө.

34.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

35 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, албаны үнэмлэх

35.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.

35.2.Гүйцэтгэх ажил үүргийн онцлогоос хамаарч дүрэмт хувцсыг өдөр тутам хэрэглэхгүй байж болно.

⁵ Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Хөдөлмөрийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Хөдөлмөрийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

35.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загвар, өмсөх дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

35.4.Дээд офицероос бусад төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалын цэргийн цолны зэрэглэлийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тогтооно.

35.5.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, тэргүүн дэд дарга цэргийн дээд цолтой байна.

35.6.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад цэргийн цол хэрэглэх, олгох, бууруулах, хураан авах, сэргээх харилцааг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль⁸д заасан холбогдох журмын дагуу зохицуулна.

35.7.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь байгууллагаас олгосон албаны үнэмлэхтэй байх ба албаны үнэмлэхний загварыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

35.8.Хүн, хуулийн этгээд төрийн тусгай хамгаалалтын албаны дүрэмт хувцас, үнэмлэхтэй ижил загварын хувцас, үнэмлэх хэрэглэхийг хориглоно.

35.9.Алба хаагч цэргийн тэтгэвэр тогтоолгох болон цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үндэслэлээр албанаас бэлтгэлээр чөлөөлөгдсөн бол дүрэмт хувцсыг түүнд хадгалуулна.

35.10.Энэ хуулийн 35.9-д зааснаас бусад үндэслэлээр төрийн тусгай хамгаалалтын албанаас чөлөөлөгдсөн, халагдсан болон өөр ажилд томилогдсон, сонгогдсон тохиолдолд дүрэмт хувцсыг хураан авна.

36 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаах нас

36.1.Ажлын шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан энэ хуульд заасан шаардлагыг хангасан 35 хүртэлх насны иргэнийг төрийн тусгай хамгаалалтын албанд томилж цэргийн цол олгож болно.

36.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаах насны дээд хязгаарыг Цэргийн албаны тухай хууль⁹д заасан ахлагчийн болон офицерийн алба хаах насны дээд хязгаартай адилтган тооцно.

36.3.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн алба хаах хугацааг түүний хүсэлтийг үндэслэн Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

⁸ Цэргийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Цэргийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.

36.4.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч алба хаах насны дээд хязгаарт хүрмэгц албанаас чөлөөлөгдөх, дахин нэг жилээр сунгуулах тухай хүсэлтээ насны дээд хязгаарт хүрэх хугацаа болохоос 3 сарын өмнө гаргаагүй нь захиргааны санаачилгаар түүнийг албанаас чөлөөлөхөд саад болохгүй.

36.5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаах насны дээд хязгаарт Төрийн албаны тухай хууль¹⁰д заасан төрийн алба хаах насны хязгаар хамаарахгүй.

37 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх

37.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ дараах эрх эдэлнэ:

37.1.1.төрийн тусгай хамгаалалттай холбогдсон хүсэлт, шаардлагыг иргэн, албан тушаалтанд тавих, дэмжлэг туслалцаа авах;

37.1.2.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, эсхүл хуулийн дагуу явуулж байгаа ажиллагаанд нь саад учруулсан бол албадан хэрэгжүүлэх;

37.1.3.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн тусгай хамгаалалтын түр бүс тогтоох;

37.1.4.шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулах;

37.1.5.аюулгүй байдлын үзлэг хийх;

37.1.6.төрийн тусгай хамгаалалтын ажлын зорилгоор иргэний бичиг баримт шалгах, эд зүйлд үзлэг хийх;

37.1.7.зэвсэг, зэвсгийн чанартай зүйл, тэсэрч дэлбэрэх, хордуулах бодис илэрвэл хураан авах, холбогдох байгууллагад шилжүүлэх;

37.1.8.хуулиар хязгаарласан, хориглосон зүйл илэрсэн тохиолдолд хураан авах, тухайн хүнийг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, химийн хорт бодист хордсоны улмаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон хүнийг 4 цаг хүртэл хугацаагаар түр саатуулах, холбогдох байгууллагад шилжүүлэх;

37.1.9.төрийн тусгай хамгаалалтын бүс, түүний орчинд шүүхээс эрүүгийн гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байгаа этгээд, оргосон ялтан илэрвэл түүнийг түр саатуулах, бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, холбогдох байгууллагад шилжүүлэх;

37.1.10.төрийн тусгай хамгаалалтын дэглэм, тогтоосон дэг журмыг сахихыг шаардах, шаардлага биелүүлээгүй иргэн, албан тушаалтныг хамгаалалтын бүсээс албадан гаргах, дахин нэвтрүүлэхгүй байх;

¹⁰ Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

37.1.11.хамгаалуулагчийн хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлээс сорьц авч шинжилгээ хийх, ашиглахыг хориглох, төрийн тусгай хамгаалалтын бүсэд ажиллах бусад байгууллагын ажилтанд зааварчилгаа өгөх, хяналт тавих;

37.1.12.шаардлагатай бол хуулиар хориглосноос бусад тээврийн хэрэгсэл дайчлах;

37.1.13.төрийн тусгай хамгаалалтын ажлын шаардлагаар байр, орон сууцанд оршин суугчийн зөвшөөрлөөр нэвтрэн орох, үзлэг хийх;

37.1.14.төрийн тусгай хамгаалалтын ажлын шаардлагаар албан байгууллага, аж ахуйн нэгжийн барилга, байгууламжид нэвтрэн орох, бичиг баримт шалгах, үзлэг хийх, шаардлага тавих;

37.1.15.зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүчийг тогтоосон үндэслэл, журмын дагуу хэрэглэх;

37.1.16.дуу-дүрсний бичлэг хийх техник хэрэгсэл ашиглах;

37.1.17.ажлын зайлшгүй шаардлагатай үед агаарын болон төмөр замын тээврийн хэрэгслийн тасалбарыг дараалал харгалзахгүй авах, тасалбар дууссан тохиолдолд тухайн тээврийн хэрэгслээр зорчих хүсэлтийг холбогдох албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;

37.1.18.амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлаа аливаа халдлагаас хамгаалах, өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулах, зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

37.1.19.хуульд заасан бусад.

38 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүрэг

38.1.Төрийн тусгай алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ дараах үүргийг хэрэгжүүлнэ:

38.1.1.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх;

38.1.2.хамгаалалтын бүсэд хамгаалалтын дэглэм, тогтоосон дэг журмыг зөрчихөөс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

38.1.3.хамгаалалтын бүсэд гарсан зөрчил, гэмт халдлагыг таслан зогсоох;

38.1.4.үүрэг гүйцэтгэж байхдаа ажлын байраа шууд захирах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр орхиж явахгүй, бусдад шилжүүлэхгүй байх;

38.1.5.албан үүргийнхээ дагуу олж мэдсэн нууцыг хамгаалах;

38.1.6.хамгаалуулагчийн хувийн мэдээллийг чанд хадгалах;

38.1.7.өргөсөн тангарагтаа үнэнч байх;

38.1.8.өөрийн бие бялдар, эрүүл мэнд, мэргэжил, мэргэшил, албаны бэлтгэлийн түвшинг эрхэлж байгаа албан тушаалд тавигдах шалгуурт нийцүүлж байх;

38.1.9.үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандах;

38.1.10.гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа бол энэ тухайгаа шууд захирах албан тушаалтанд даруй мэдэгдэх;

38.1.11.албан үүргээ гүйцэтгэж байхдаа энэ хуулийг хэрэгжүүлэхэд чиглэснээс бусад үйл ажиллагаа явуулахгүй байх.

39 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид тавих ёс зүйн тусгай шаардлага

39.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрийг бусад алба хаагч биелүүлэх үүрэгтэй. Удирдах албан тушаалтны шийдвэр хууль тогтоомж болон энэ хуулийн 39.2-т нийцсэн байна.

39.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид дараах зүйлийг хориглоно:

39.2.1.хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах;

39.2.2.албан тушаал, байгууллагын нэр болон хамгаалуулагчийн нэр төрийг хувийн болон улс төрийн зорилгоор ашиглах;

39.2.3.хамгаалуулагч, түүний гэр бүл, дотны хүмүүст хувийн хүсэлт тавих, бусдын хүсэлтийг дамжуулах;

39.2.4.албан үүргээ гүйцэтгэх болон албаны бэлэн байдал зарласан үед, ажлын байранд болон дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх;

39.2.5.мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх;

39.2.6.хамгаалуулагчийн тухай өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх, хэвлэн нийтлэх;

39.2.7.улс төрийн нам, эвсэл, холбоо, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, тэдгээрийн үйл ажиллагааг сурталчлах, дэмжлэг үзүүлэх;

39.2.8.албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглах, аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглах;

39.2.9.албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан илэрхий болсон, албан үүргийн дагуу олж мэдсэн төрийн нууц, албаны нууц, байгууллагын нууц болон хувь хүний эмзэг мэдээллийг задруулах;

39.2.10.удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэх, мэдээлэл дамжуулах;

39.2.11.ажил хаях, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

39.2.12.төрийн албан хаагчид хуулиар хориглосон бусад.

40 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн баталгаа

40.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Төрийн албаны тухай хууль¹¹ тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшлаас гадна энэ хуульд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангагдана.

40.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль¹²д заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна.

40.3.Энэ хуулийн 40.1, 40.2-т заасан баталгааг төрийн тусгай хамгаалалтын албан хаагчид эдлүүлэхдээ ижил төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдлийг давхардуулж олгохгүй бөгөөд сонголтыг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч өөрөө хийнэ.

40.4.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдэлнэ.

41 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн улс төрийн баталгаа

41.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглоно.

41.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг энэ хуулийн 41.1-д заасан үйл ажиллагаанд оролцохыг шаардсан бол татгалзана.

42 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хууль зүйн баталгаа

42.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ажлыг шууд удирдах даргад нь мэдэгдэлгүйгээр шалгах, албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, албан үүргээ гүйцэтгэж байхад нь саатуулах, бие, эд зүйлд нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

42.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг албан тушаалын чиг үүрэгт нь нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

42.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаас ажил үүрэгтэй нь холбоотой асуудлаар гэрч, хохирогчийн хувиар мэдүүлэг авах тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргад мэдэгдэнэ.

¹¹ Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

¹² Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

42.4.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол Монгол Улсын Ерөнхий сайдад, бусад алба хаагчийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

42.5.Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна.

42.6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс бусдад учирсан хохирлыг төр хариуцна.

42.7.Эрх бүхий албан тушаалтны өгсөн тушаал, үүрэг даалгаврыг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ёсчлон биелүүлснээс үүссэн үр дагаврыг тушаал, үүрэг даалгавар өгсөн албан тушаалтан хариуцна.

42.8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, ажлаас харих замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно.

42.9.Энэ хуулийн 42.8-д зааснаас гадна дор дурдсан нөхцлийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно:

42.9.1.байгууллагын захиалгаар дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцах;

42.9.2.энхийг дэмжих ажиллагаанд оролцох.

42.10.Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч болон түүний гэр бүлийн гишүүний амь биед аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авах асуудлыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хариуцна.

42.11.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийг гүйцэтгэх ажлын зорилгоор ашиглахыг хориглоно.

42.12.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

43 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн нийгмийн баталгаа

43.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг түүний гэр бүлд нэг удаа олгоно.

43.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад гэмт халдлагын улмаас эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан, эсхүл албанаас чөлөөлөгдсөн иргэний урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан амь насанд нь хохирол учруулсны улмаас нас барсан бол энэ хуулийн 43.1-д заасан баталгаа нэгэн адил хамаарна.

43.3.Энэ хуулийн 43.1-д заасан тэтгэмжийн зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

43.4.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараахь нөхөх олговор, тусламж олгоно:

43.4.1.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор;

43.4.2.хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;

43.4.3.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү.

43.5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрт энэ зүйлийн 43.4.3-т заасан цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.

43.6.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

43.7.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.

43.8.Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон төрийн тусгай хамгаалалтын алба хаагч, уг үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхтэй холбоотой зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.

43.9.Энэ хуулийн 43.4-т заасан нөхөх олговор, тусламж олгох журам, 43.8-д заасан зардал олгох журмыг Засгийн газар батална.

43.10.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтын албанд ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно.

44 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эдийн засгийн баталгаа

44.1.Засгийн газар төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

44.2.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагчийг төрөөс орон сууцаар хангана.

44.3.Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шөнийн ээлжинд ажиллах үед хоол, унааны зардал, хээрийн сургууль, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амраах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана.

44.4.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын захиалгаар гадаад улсын их, дээд сургуульд суралцагч төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн суралцах хугацааны сургалтын зардал, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.

44.5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цалин хөлс нь дараах цалин, нэмэгдлээс бүрдэнэ:

- 44.5.1.албан тушаалын үндсэн цалин;
- 44.5.2.цэргийн цолны цалин;
- 44.5.3.төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл;
- 44.5.4.албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл;
- 44.5.5.мэргэшлийн зэргийн нэмэгдэл;
- 44.5.6.эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл;
- 44.5.7.хуульд заасан бусад.

44.6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн тусгай алба хаасан хугацааны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.

44.7.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цэргийн цолны цалингийн хувь хэмжээг цэргийн цолны цалингийн хэмжээ тогтоосон хууль тогтоомжид зааснаар тооцно.

45 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүй, сахилгын хариуцлага

45.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн сахилгын дүрмийг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

45.2.Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид Төрийн албаны тухай хууль¹³д зааснаас гадна дараах сахилгын шийтгэл ногдуулна:

- 45.2.1.цэргийн цол бууруулах;
- 45.2.2.албан тушаал бууруулах.

45.3.Албан тушаал бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид буурсан албан тушаалын цэргийн цолыг эдлүүлэхээр гаргасан шийдвэр нь энэ хуулийн 45.2.1-д заасан сахилгын шийтгэлд хамаарахгүй.

¹³ Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

45.4.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид Зөрчлийн тухай хууль¹⁴, Эрүүгийн хууль¹⁵д заасан хариуцлага хүлээлгэсэн нь сахилгын шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

46 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх

46.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг албан ажлын шаардлага, алба хаагчийн хүсэлт, албан тушаал, орон тоо нь цомхотгогдсон, тухайн албан тушаалыг урьд өмнө эрхэлж байсан алба хаагчийг эгүүлэн тогтоох тухай шүүхийн шийдвэр гарсан, эсхүл эрүүл мэндийн хувьд албан тушаалын үүрэгтээ тэнцэхгүй тухай эмнэлгийн байгууллагын дүгнэлт гарсан бол өөр албан тушаалд ажиллуулахаар шилжүүлэн томилж болно.

47 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг албанаас чөлөөлөх

47.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна дараах үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлж болно:

47.1.1.бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр албан тушаал, орон тоо нь цомхотгогдсон;

47.1.2.эрүүл мэндийн хувьд албан тушаалын үүрэгтээ тэнцэхгүй тухай эмнэлгийн байгууллагын дүгнэлт гарсан;

47.1.3.төрийн тусгай хамгаалалтын алба хаах насны дээд хязгаарт хүрсэн.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД БИЕЙН ХҮЧ, ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ТЕХНИК, АЛБАНЫ НОХОЙ ХЭРЭГЛЭХ

48 дугаар зүйл.Биеийн хүч, зэвсэг, тусгай хэрэгсэл, албаны нохой хэрэглэх нийтлэг үндэслэл

48.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, алба хаагч төрийн тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, албаны нохой хэрэглэж болно.

48.2.Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх сургалтад хамрагдан, эрх олгогдсон төрийн тусгай хамгаалалтын алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл биедээ авч явах, хэрэглэх эрхтэй.

¹⁴ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

¹⁵ Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

48.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч энэ хуульд заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн нөхцөл байдлыг өөрийн дотоод итгэлээр үнэлж, биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгслийг сонгон хэрэглэх эрхтэй.

48.4.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх галт зэвсэг, сум, тусгай хэрэгслийн жагсаалт, тэдгээрийг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журам болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх бэлтгэл хангах журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

48.5.Төрийн тусгай хамгаалалтад биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

48.6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник хэрэглэхдээ дараах нийтлэг шаардлагыг баримтална:

48.6.1.зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх;

48.6.2.тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх;

48.6.3.хамгаалуулагч болон хамгаалж байгаа объектын аюулгүй байдалд заналхийлж буй нөлөөллийг бодитоор үнэлж, өөрийн дотоод итгэл үнэмшлийн дагуу хэрэглэх.

48.7.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын даргын шийдвэрээр албан хэрэгцээнд хүлээн авч, бүртгэсэн тусгай хэрэгсэл, галт зэвсэг, сум, бусад хэрэгслийг хэрэглэнэ.

48.8.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, албаны нохой хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй.

48.9.Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэснээс хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь эмнэлгийн байгууллага, захирах даргадаа, захирах дарга нь прокурорт тус тус нэн даруй мэдэгдэнэ.

49 дүгээр зүйл.Биеийн хүч хэрэглэх

49.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь дараах тохиолдолд биеийн хүч хэрэглэж болно:

49.1.1.хамгаалуулагчийн зорчин явах замыг чөлөөлөх үед зайлшгүй тохиолдолд;

49.1.2.төрийн тусгай хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүйгээр нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан;

49.1.3.төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд саад учруулсан болон хамгаалалтын дэглэм зөрчсөн;

49.1.4.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг заналхийлсэн, доромжилсон, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байсан, эсэргүүцсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан;

49.1.5.хамгаалалтын бүсэд нэвтрүүлэхийг завдсан хориглосон, хязгаарласан эд зүйлийг хураан авахад эсэргүүцэл үзүүлсэн;

49.1.6.галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.

50 дугаар зүйл.Тусгай хэрэгслийн төрөл

50.1.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх тусгай хэрэгсэл нь дараах төрөлтэй байна:

- 50.1.1.нэг бүрийн;
- 50.1.2.олон хүнд нөлөөлөх;
- 50.1.3.бусад.

50.2.Төрийн тусгай хамгаалалтад нисдэг тэрэг, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, нисэгчгүй нисэх төхөөрөмж албадан буулгах техник хэрэгсэл, галт хэрэглэл, гэрэл, дууны хэрэгсэл, согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг шалгагч болон бусад тусгай хэрэгсэл ашиглаж болно.

50.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийгөө болон хамгаалуулагчийг хамгаалах тусгай хэрэгслээр хангагдана.

51 дүгээр зүйл.Нэг бүрийн тусгай хэрэгсэл

51.1.төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

- 51.1.1.гав;
- 51.1.2.хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл;
- 51.1.3.бороохой;
- 51.1.4.цахилгаан гүйдлээр цохигч;
- 51.1.5.хутга;
- 51.1.6.нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;
- 51.1.7.резин болон хуванцар сумтай буу;
- 51.1.8.нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.

51.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч биедээ энэ хуулийн 51.1-д заасан тусгай хэрэгсэл байхгүй тохиолдолд гарцаагүй байдал, аргагүй хамгаалалт болсон үед гарын доорх эд зүйлийг тусгай хэрэгслийн зориулалтаар ашиглаж болно.

52 дугаар зүйл.Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх

52.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараах тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэж болно:

52.1.1.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг хүч хэрэглэн эсэргүүцсэн;

52.1.2.түр саатуулагдсан этгээд өөрийгөө гэмтээх нөхцөл байдал үүссэн, тухайн этгээдийг зэвсэг хэрэглэн суллахаар завдсан буюу халдсан, хэрэглэсэн эсхүл бүлэглэн довтолсон үед;

52.1.3.төрийн тусгай хамгаалалтын бүсэд хүч хэрэглэн хууль бусаар нэвтрэхийг завдсан, нэвтэрсэн;

52.1.4.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцсэн;

52.1.5.хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн биед халдсан буюу халдахыг завдсан;

52.1.6.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд зэвсгийн чанартай зүйл хэрэглэн халдсан буюу халдахыг завдсан;

52.1.7.олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.

53 дугаар зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл

53.1.Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна:

53.1.1.олон хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч;

53.1.2.усан хөөрөг;

53.1.3.утаан хөшиг үүсгэгч;

53.1.4.олон хүнд нөлөөлөх бусад тусгай хэрэгсэл.

54 дүгээр зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх

54.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга, түүний эрх олгосноор тухайн хамгаалалтыг удирдаж байгаа албан тушаалтын шийдвэрээр олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

54.2.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ:

54.2.1.төрийн тусгай хамгаалалтын бүсэд үүссэн эмх замбараагүй байдлыг өөр аргаар таслан зогсоох боломжгүй үед;

54.2.2.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтын авсан барилга, бусад зүйл руу бүлэглэн довтолсон үед таслан зогсоохоор, бүслэн хаалтаас чөлөөлөх үед;

54.2.3.галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, шатамхай бодис, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч хий болон хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх химийн бодис зэрэг зүйлсээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг эсэргүүцсэн үед;

54.2.4.галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.

55 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх

55.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараах тохиолдолд тээврийн хэрэгсэл албадах зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэнэ:

55.1.1.автотээврийн хэрэгсэл ашиглан хамгаалуулагч болон хамгаалалтад авагдсан барилга, бусад зүйл рүү довтолсон;

55.1.2.тээврийн хэрэгслээр төрийн тусгай хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан;

55.1.3.төрийн тусгай хамгаалалтын бүсэд автотээврийн хэрэгсэл ашиглан жагсаал, цуглаан хийж нэвтрэхийг завдсан, нэвтэрсэн;

55.1.4.автотээврийн хэрэгслийг зогсоох талаар өгсөн ойлгогдохуйц дохио, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн;

55.1.5.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг барьцаалан тээврийн хэрэгсэл ашиглан зугтаасан.

55.2.Автотээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэх боломжгүй тохиолдолд автомашин болон бусад зүйлээр хаалт тавьж болно.

55.3.Автотээврийн хэрэгслийг албадан зогсоосны улмаас учирсан хохирлыг тухайн автотээврийн хэрэгслийг жолоодож явсан хүн хариуцана.

56 дугаар зүйл.Нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгийг албадан буулгах тусгай хэрэгсэл хэрэглэх

56.1.Төрийн тусгай хамгаалалтын бүсийн агаарын зайд нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгийг зөвшөөрөлгүй нисгэсэн тохиолдолд албадан буулгах тусгай хэрэгсэл хэрэглэж буулгана.

56.2.Албадан буулгах тусгай хэрэгсэл хэрэглэсний улмаас учирсан хохирлыг тухайн нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгийг нисгэсэн этгээд хариуцана.

57 дугаар зүйл.Албаны нохой ашиглах

57.1.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд албаны нохой ашиглаж болно.

57.2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч өөрийн болон хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй, зэвсэглэсэн этгээд довтолсноос бусад тохиолдолд хүний эсрэг албаны нохой ашиглахыг хориглоно.

57.3.Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журмыг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

58 дугаар зүйл.Галт зэвсэг хэрэглэх үндэслэл

58.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

58.1.1.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйл, үүргээ гүйцэтгэж байгаа төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид галт зэвсэг хэрэглэн халдсан буюу халдахыг завдсан;

58.1.2.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар халдсан буюу халдахаар завдсан этгээдийн үйлдлийг өөр аргаар таслан зогсоох боломжгүй;

58.1.3.хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийг барьцаанд авахаар завдсан үйлдлийг таслан зогсоох, барьцаанаас чөлөөлөх.

58.1.4.төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн галт зэвсгийг булаахаар довтолсон;

58.1.5.хамгаалуулагчийн болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хор уршиг учруулж болзошгүй болон учруулж байгаа амьтныг устгах.

58.2.Галт зэвсгийг түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах, бэлтгэл, сургуулилтын болон хуульд заасан бусад тохиолдолд хэрэглэж болно.

59 дүгээр зүйл.Галт зэвсэг хэрэглэх

59.1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бодит эрсдэл үүссэн нөхцөлд галт зэвсгийг шууд хэрэглэж болно. Боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

60 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

60.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

60.2.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, өргөсөн тангаргаа зөрчсөн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол энэ хууль, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн сахилгын дүрмийг баримтлан сахилгын шийтгэл оногдуулна.

60.3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албаны эд хөрөнгө, зэвсэг, тусгай хэрэгслийг санаатайгаар эвдэж үрэгдүүлсэн бол эд хөрөнгийн хариуцлагыг учруулсан бодит хэмжээгээр хүлээлгэнэ.

60.4.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч дараахь тохиолдолд эд хөрөнгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө:

60.4.1.албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэсний улмаас учирсан хохирол;

60.4.2.гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, онцгой нөхцөл байдлын улмаас учирсан хохирол.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.1995 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр баталсан Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр баталсан Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “яамны Төрийн нарийн бичгийн дарга” гэсний дараа “болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын албан хаагч” гэж, мөн зүйлийн 8.5 дахь хэсгийн “өмгөөлөгчийн” гэсний дараа “болон төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн “техникийн үзлэг, шалгалт” гэснийг “хамгаалалтын техникийн үзлэг” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.11 дэх хэсгийн “тусгай” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар

ХОТ

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтын “улсын батлан хамгаалах” гэсний дараа “, төрийн тусгай хамгаалалтын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 14 дэх заалт нэмсүгэй:

“14/төрийн тусгай хамгаалалтын байгууллагын төрийн тусгай хамгаалалтын зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрын.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалтын “Тагнуулын ерөнхий газартай” гэснийг “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Радио долгионы тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хэрэгцээнд” гэсний дараа “болон төрийн тусгай хамгаалалтад” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийн “тусгай” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “төрийн тусгай хамгаалалтын газар” гэснийг “цагдаагийн байгууллага” гэж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга” гэснийг “Цагдаагийн төв байгууллагын дарга” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “тусгай” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 7 дахь заалт нэмсүгэй.

“7/Төрийн тусгай хамгаалалтын байнгын бүсэд”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “төрийн тусгай хамгаалалтын” гэснийг, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийн “төрийн тусгай хамгаалалтын асуудал хариуцсан байгууллага” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийн “төрийн тусгай хамгаалалтын асуудал эрхэлсэн байгууллага” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “төрийн тусгай хамгаалалтын” гэснийг, 61 дүгээр зүйлийн 61.3 дахь хэсгийн “болон төрийн тусгай хамгаалалтын асуудал эрхэлсэн байгууллага” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын “Төрийн тусгай хамгаалалтын газар” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ОРДНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “төрийн ёслолын асуудал хариуцсан байгууллага” гэсний дараа “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай хамтран” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:

“5.2.Төрийн ордны халдашгүй дархан байдлыг энэ хуультай нийцүүлэн гаргасан хамгаалалт, үйлчилгээ, нэвтрэх тусгай журмууд болон Төрийн ордонд баримтлах дэг журмын дагуу хангана.”

2/7 дугаар зүйл.**“7 дугаар зүйл.Төрийн ордны хамгаалалт**

7.1.Төрийн ордон нь Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 10.2.1-д заасны дагуу төрийн тусгай хамгаалалтад байна.

7.2.Төрийн ордныг Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгж (цаашид “Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгж” гэх) 24 цагаар тасралтгүй хамгаалж, аюулгүй байдлыг хангах, тогтоосон дэг журмыг сахиулах асуудлыг хариуцна.

7.3.Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгж энэ хуулийн 3.2-т заасны дагуу Монгол Улсын Их хурлаас тогтоосон нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг бүхэлд нь хариуцна.

7.4.Төрийн ордон нь түүнд байрлаж үйл ажиллагаа явуулдаг байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах холбоо, аюулгүй байдлыг хангах тусгай техник хэрэгслээр тоноглогдсон байна.

7.5.Төрийн ордны аюулгүй байдлыг хангах зорилгоор шалган нэвтрүүлэх болон тусгай хяналтын техник, хэрэгслийг суурилуулах бөгөөд төрийн тусгай хамгаалалтын алба хаагч үзлэг хийх нэг бүрийн хэрэгслээр хангагдсан байна.

7.6.Төрийн ордонд нэвтрэх тусгай журам болон Төрийн ордонд баримтлах дэг журмыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар,

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн тусгай хамгаалалтын байгууллага хамтран батална.

7.7.Төрийн ордны хамгаалалтын тусгай журмыг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 32.1.3-т заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.

7.8.Иргэд, байгууллагын тодорхой үйлдлийн улмаас Төрийн ордонд байрладаг байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтийг үндэслэн цагдаагийн төв байгууллагын дарга болон дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр Төрийн ордныг хүч нэмэгдүүлэн хамгаалж болно.”

3 дугаар зүйл. Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “үнэмлэх, нэвтрэх хуудсаа” гэснийг “тогтоосон журмын дагуу” гэж, мөн зүйлийн 8.3 дахь хэсгийн “хамгаалалтын албаны эрх бүхий албан тушаалтнаас” гэснийг “Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгжээс” гэж, мөн зүйлийн 8.6 дахь хэсгийн “Төрийн ордны хамгаалалтын албанаас” гэснийг “Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгжээс” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “үйлчилгээ явуулах болон засвар хийх” гэснийг “үйлчилгээний тусгай” гэж, мөн хэсгийн “Төрийн ордны хамгаалалтын албатай” гэснийг “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

Гарын үсэг